

ЕСҮСИЙГ Бодъё

НУТГИЙН ЖИЖИГ БҮЛГҮҮДЭД ЗОРИУЛСАН
10 ДОЛОО ХОНОГИЙН СТРАТЕГИ



Есүсийг Бодъё

Нутгийн Жижиг Бүлгүүдэд Зориулсан 10 Долоо Хоногийн Стратеги

*Есүс гэж хэн болох, Түүнийг дагах нь ямар утга
учиртайг хүмүүст сайтар ойлгуулахын тулд
Магдалена: Ичгүүрээс Чөлөөлөгдсөн нь киног
ашиглаарай.*

УДИРДАГЧИЙН ХӨТӨЧ

Бурхан орон нутагт тань хаанчлалаа байгуулахын тулд таныг чухал арга замаар хэрэглэнэ.

Есүсийн мөн чанарыг таньж мэдсэн мөчөө санах хэсэг хормыг гаргаарай – Түүний өрөвч сэтгэл, Түүний дөлгөөн зөөлөн зан, Түүний ариун чанар, Түүний сайхан сэтгэл, Түүний сүр жавхлан. Тэр бол таны найдсан бүхэн, таныг аварч, чөлөөлөх бүхэн. Тэр бол таны найдвар, бүх үндэстэн, бүх хүмүүсийн найдвар.

Элч Иохан Илчлэл номд ийн бичжээ:

“Харагтун, үүний дараа намайг харахад, сэнтийн өмнө болон Хурганы өмнө зогсон, цагаан дээл өмссөн, гартаа далдуу модны найлзуур барьсан, үндэстэн бүрээс, бүх овгоос, бүх ард түмнээс, бүх хэлтнээс ирсэн үй олон хүн байв. Хэн ч тэднийг тоолж чадамгүй ажээ. Тэд чанга дуугаар — Аврал бол сэнтийд залрагч бидний Бурханд ба Хурганд байдаг гээд хашхирч байлаа.” (Илчлэл 7:9-10)

Хаадын Хааны талаарх хүчирхэг мэдлэг танд бий. Түүний талаар мэдэх бүхнээ бусдад хуваалцаж, Бурханы гэр бүлийнд хамтдаа өсөхөд тань бид таныг бэлтгэж чадваржуулахыг эрмэлздэг.

Матайн Сайнмэдээний хамгийн сүүлийн эшлэлд Есүсийн айлдсан үгийн тэмдэглэжээ:

“Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуулагтун, Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ, та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав.” (Матай 28:19-20)

Тэрээр бидэнд яв, тэднийг дагалдагч болго, тэдэнд заа, үргэлж бидэнтэй хамт байж, уул толгод, хөндий бүрээр бидэнтэй хамт явна гэсэн. *Есүсийг Бодъё* хөтөлбөр сайн стратегийг санал болгодог. Есүсийг гүнзгий танин мэдэхийн тулд хамтдаа суралцахад амьдралаа зориулах үнэнч дагалдагчдыг төлөвшүүлэхийн тулд үүнийг ашиглаарай.

Есүсийг Бодъё Магдалена Маригийн нүдээр болон түүний гэрчлэлээр Есүсийн түүхийг харуулсан Магдалена: *Ичгүүрээс Чөлөөлөгдсөн нь* киноны хэсгүүдээс ашиглан бэлтгэсэн бөгөөд гэр бүлийн гишүүд, найз нөхөд болон танилуудтайгаа жижиг бүлийн уулзалт хийхэд ашиглаж болох сайхан гарын авлага юм. Киноны хэсгээс хамтдаа үзээд оролцогч бүр Есүсийн амьдрал, гайхамшиг, үхэл, дахин амиллын талаар илүү ихийг сурах боломжтой. Есүсийн мөн чанарын улмаас олонх нь дагадаг бол заримд нь Түүний тухай илүү ихийг сурах боломж хэрэгтэй байдаг. *Есүсийг Бодъё* цувралын төгсгөлд Есүс Кино Төслийн® бэлтгэсэн *Ривка* эсвэл *Есүсийг Мэдэхүй* зэрэг хөтөлбөрийг ашиглан жижиг бүлгийг үргэлжлүүлэх боломжтой.

Есүсийг Бодъё хөтөлбөрийг ашиглах алхмууд.

Хэнд хүрэхээ тодорхойл

Та хэнд Есүсийн тухай илүү ихийг мэдүүлэхийг хүсэж байна вэ? Есүсийг танин мэдэх хэрэгтэй хүмүүс танай хороолол эсвэл ойролцоо сууринд байна уу? Найзууд эсвэл хамт ажиллагсад?

Нэгт, тухайн газар дахь “амар тайвны хүнийг” илрүүлээрэй. Лук 10:6-р эшлэлд Есүс сургаалаа тунхаглуулахаар 72 дагалдагчдаа илгээж, очих газарт нь тэндийг хүлээн авах амар тайвны хүнийг олоорой хэмээн зааварласан.

Амар тайвны хүн заавал итгэгч байх шаардлагагүй ч дараах шинж чанартай байх учиртай:

- Христ болон Түүний сургаалд нээлттэй
- Орон нутагтаа танигдсан эсвэл нөлөөтэй
- Таны сонгосон нутаг дахь хүмүүстэй таныг холбож өгөх боломжтой, хүсэлтэй байх
- *Магдалена* киног үзүүлэхээр хүмүүсийг урихад тань туслах хүсэлтэй

Ийм хүнтэй харилцаа үүсгэж холбоо тогтоогоорой. Та амар тайвны хүнтэйгээ харилцах харилцаагаа хөгжүүлэхдээ дараах гурван алхамт явцыг заавар болгон ашиглаарай.

а. Залбирал

Амар тайвны хүний төлөө залбир. Бурхан танд өөрийн гэр бүл болон найз нөхөдтэйгөө танилцуулах амар тайвны хүн хэн болохыг харуулахын төлөө залбир. Энэ хүнийг таньж мэдээд түүний юунд санаа тавьж залбирах хэрэгтэйг асуугаарай.

б. Халамж

Шинэхэн найзынхаа төлөө залбирч, хэрэгцээг нь ойлгож эхлэхдээ тэднийг сонсож, илэрхийлэгдсэн хэрэгцээг хангаж буйгаараа санаа тавьдгаа илэрхийлээрэй. Жинхэнэ, урамшуулагч найз байгаарай.

в. Хуваалцах

Хүмүүсийг сонсож, хэрэгцээнийх нь дагуу тэдэнд тусалснаар Есүсийн сайнмэдээг хуваалцах эрхэм боломж бидэнд өгөгддөг. Хэрэв тэд мэдэхгүй бол, боломж бүрдэхэд Есүсийн сайнмэдээ, Түүний өршөөлийг амар тайвны хүндээ хуваалцаарай.

Магдалена: Ичгүүрээс Чөлөөлөгдсөн нь Үзүүлэх

Уг стратегийн хувьд бид эмэгтэйчүүдийн бүлгийг жишээ болгон ашиглая. Гэвч эрчүүд болон гэр бүлийн хүрээнд *Есүсийг Бодъё* хөтөлбөрийг ашиглаж болно!

Амар тайвны хүний хамтаар *Магдалена* кинонд бүсгүйчүүдийг уриарай. Боломжтой амар тайвны хүний гэрт урьж болох юм. Хамтдаа хооллоод дараа нь киногоо үзээрэй, ам зугаа эсвэл ундаагаар дайлаарай. Оролцогч бүрд санаа тавьж, өгөөмрөөр дайлаарай.

Магдалена кино Есүс Кино Төслийн вэбсайт болон Есүсийн кино төслийн апп дээр 200 гаруй хэлээр үнэ төлбөргүй байдаг. Хэрэв танд USB оролттой телевизор байгаа бол *Магдалена* киног флаш диск ашиглана үзүүлээрэй. Хэрэв танд Bluetooth чанга яригчтай таблет төхөөрөмж байгаа бол 10 хүртэлх хүнтэй жижиг бүлэгт эсвэл бүр илүү том газарт уг киног үзүүлэх боломжтой.

Киноны төгсгөлд үзэгчдийг цаашдын хоёр үйл ажиллагаанд уриарай:

Нэгт, эмэгтэйчүүдийг Есүсийн дагалдагч болоход уриалах. Өөрийн гэрчлэл болон үзсэн кинотой холбоотой түүхийг хуваалцаж болно.

Хоёрт, дараагийн өдөр Есүсийн тухай илүү ихийг ярих уулзалтад урих! Сонирхож магадгүй найз нөхдөө дагуулж ирэхийг ятгаарай. Улмаар *Есүсийг Бодъё* хөтөлбөрийн дагуу Христийн түүхүүдийг судалж эхлэх ба тэдэнд байгаа асуултуудад хариулж болно.

Дараа нь оролцсон эмэгтэйчүүдтэй танилцах цаг гаргаарай. Кинонд өгүүлэх түүх болон сэдвүүд тэдний амьдралын зарим нэг хүнд түүхүүдийг ил гаргаж болох юм. Хэрэв шаардлагатай бол тэдний төлөө залбираарай.

Одоо хамгийн шилдэг хэсэг эхэллээ!

Есүсийг Бодъё Нутгийн Шинэ Бүлэг Эхлэх

Есүсийн талаар сонирхон бодож байгаа эмэгтэй бүрийн төлөө залбираарай. Мөн жижиг бүлгийн уулзалтаар Ариун Сүнс тэдний зүрх сэтгэлийг зөөллөхийн төлөө залбираарай. Есүсийн түүх бүр тэдэнд гүн, ач холбогдолтойгоор нөлөөлж, сонсогч бүр түүх бүрийг өөртөө тусган авахын төлөө залбираарай.

Эл уулзалт болон дараах уулзалтад та *Магдалена* киноны арван хэсгийг ашиглаж Есүсийн тухай илүү их сурч мөн Түүний тухай ярилцана. Хэсэг бүрийн ерөнхий сэдвүүдийг дурдвал:

1. Эмэгтэй Бүрийг Хардаг, Мэддэг
2. Есүс: Зөнчөөс Илүү Нэгэн
3. Хүлээснээс Чөлөөлөгдсөн нь
4. Есүсийн Өршөөл
5. Зөрчил ба Гадуурхал
6. Эдгэрэл ба Сэргэлт
7. Ичгүүр ба Хүндлэл
8. Есүсийг болон Түүний Өршөөлийг Мэдэхүй
9. Есүсийг Хүлээн Авах ба Бусдад Хуваалцах Эрмэлзэл
10. Есүстэй хамт Амьдрахуй

Ирэх долоо хоногийн хугацаанд шинэхэн бүлэг Есүс Христийн талаар болон Түүний дагалдагч байх нь ямар утга учиртай болохыг ойлгоно. Мөн тэд Христитгэлт хамт олны амьдралыг туршлагажин мэдэх боломжтой.

Уулзалт бүрт бид Гурваны – Гурав (3/3) хэлбэрийг ашиглан найз нөхдийн бат бөх харилцааг хөгжүүлнэ. 3/3 Хэлбэр бол уулзалтыг нийцтэй, дэг журамтай болгож, зорилго, урам зориг, төлөвшилийг баталгаажуулах бүлгийн энгийн бүтэц юм. Эл хэлбэрт: Эргэж Харах, Дээшээ Харах, Урагшаа Харах гэсэн хэсэгтэй.

Анхаар: *Есүсийг Бодъё* хөтөлбөр бол Бурханы дуудлагыг биелүүлэхэд тань туслах загвар юм. **Өөрийн соёл уламжлалын хэрэгцээнд тохируулан өөрчлөх бүрэн боломжтой!**



ГУРАВНЫ – ГУРАВ

Дагалдуулах Сургалтын Явц



ЭРГЭЖ Харах

- **Халамж:** Та хэр байгаагаа хуваалцаарай. Өөрийн амьдралын түүх, өссөн орчноо яриарай.
- **Магтаал:** Магтаалын дуу болон залбирлаар хамтдаа магтан хүндэтгээрэй.
- **Итгэмжит чанарыг тэмдэглэ:** Сурсан зүйлээ яаж хэрэгжүүлснээ ярилцаарай.
- **Алсын Хараанд Уриалах:** Есүс таны амьдралыг хэрхэн өөрчилснийг хуваалцаарай. Нэг нэгнээ урамшуулаарай.



Дээшээ Харах

- **Үзүүлэх:** Киноны хэсгүүдийг хоёр давтан үзнэ. Есүсийн тухай шинэ түүхийг хамтдаа сурна.
- **Ярих:** Киноны тус хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн хэн нэг хүнээс асуух.
- **Гүйцээх:** Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.
- **Хэлэлцүүлэг:** Байгаа цагийнхаа хэрээр аль болох олон асуултуудын дагуу ярилцаарай.



Урагшаа Харах

- **Хэрэгжүүлэх:** Сурсан зүйлээ яаж хэрэгжүүлэхээ тодорхойл.
- **Дадлагажуулах:** Нэг нэгэндээ түүхийг ярьж өгөх.
- **Хуваалцах:** Энэ түүхийг хэнд ярьж өгөхөө ярилцана.
- **Залбирах:** Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархана. Нэг нэгнийхээ төлөө болон орон нутгийн хүмүүсийнхээ төлөө залбирна.

Дараагийн алхмыг хийх

Есүсийг Бодъё хөтөлбөрийн сүүлийн хичээлээр Христитгэлт амьдралын талаар ярилцана. Эл хэсэгт Мари эрхэм зорилго болон Есүсийг дагах төлөөсний талаар бататгана. Хэрэв бүлгийн гишүүд бэлэн бол дараагийн алхамд хөтлөн чиглүүлэх нэн чухал. **Бүлгийн нэг эсвэл хэд хэдэн хүнийг өөрсдөө Есүсийг Бодъё бүлэг эхлүүлж, бусдад сурсан зүйлээ хуваалцахад уриалах сайхан боломж бол энэ юм.** Хэрэв танай бүлэг цаашид ч хамтдаа уулзах хүсэлтэй бол дараагийн шатны хөтөлбөр болох *Ривка* эсвэл *Есүсийг Мэдэхүй* хөтөлбөр лүү шилжээрэй. Эл хоёр сургалтаас та дараах мэдээллийг олж авна:

Ривка Мэдээллийн Хуудас:

www.jesusfilm.org/partners/resources/strategies/women/gather-and-grow/

Есүсийг Мэдэхүй Мэдээллийн Хуудас:

www.jesusfilm.org/partners/resources/strategies/knowning-jesus/

Есүсийг Мэдэхүй Сурталчилгааны Бичлэг:

www.youtube.com/watch?v=MkYpNK5OvKk

УДИРДАГЧИЙН ШУУРХАЙ ЛАВЛАХ ХӨТӨЧ

Киноны хэсгүүдээс яаж сурах

Есүс хүмүүний амьдралын доройтсон хэсгүүдийг хэрхэн хүчирхгээр ялан дийлснийг гэрчилсэн Маригийн амьдралын мөчүүдийг гүнзгий судлахын тулд *Магдалена* киног хэд хэдэн хэсэгт хуваасан. Өгөгдсөн зааврын дагуу тухайлсан хэсгийг илүү дэлгэрүүлэн судлаарай.

Долоо хоног бүр бүх асуултуудын дагуу судлах шаардлагагүй. Хамгийн гол нь Маригийн өөрчлөлт болон Есүсийн мөн чанарын талаар тухайн хэсгийн илэрхийлсэн агуулгын талаар бүлгийн гишүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь чухал. Мөн хөтлөгчийн хувьд бүлэгт аюулгүй орчин бүрдүүлэх нь таны хариуцлага учир сонсох болон чиглүүлэх нь таны үүрэг болно. Энэ бол номлолын цаг биш харин *бүлгийн* хэлэлцүүлэг байх учиртай.

Бичлэгүүдийг үзэхийн тулд Есүсийн Кино Төслийн апп руу орж, хайлтын цонхноос налуу бичсэн гарчгаар хэсэг бүрийг олох эсвэл Есүс Кино Төслийн вэб сайтад зочлоорой [Jesusfilm.org/watch](https://jesusfilm.org/watch).

Эл хичээлд ашиглагдсан *Магдалена* киноны хэсгүүд:

I Хичээл: Эмэгтэй Бүрийг Хардаг, Мэддэг (Хэсэг: *Мари Магдалена Ривкагийн Гэрт Очсон нь*).

II Хичээл: Есүс: Зөнчөөс Илүү Нэгэн (Хэсэг: *Марит Зарласан нь*).

III Хичээл: Хүлээснээс Чөлөөлөгдсөн нь (Хэсэг: *Мари Магдалена Чөтгөрүүдээс Чөлөөлөгдсөн нь*).

IV Хичээл: Есүсийн Энэрэл (Хэсэг: *Есүс Бэлэвсэн Эмэгтэйн Хүүг Амилуулсан нь*).

V Хичээл: Зөрчил ба Гадуурхал (Хэсэг: *Худаг дээрх Эмэгтэй*).

VI Хичээл Эдгэрэл ба Сэргэлт (Хэсэг: *Цусны Өвчтэй Эмэгтэй*).

VII Хичээл: Ичгүүр ба Хүндлэл (Хэсэг: *Завхайрсан Эмэгтэй Өршөөгдсөн нь*).

VIII Хичээл: Есүсийн Үхэл ба Амилал (Хэсэг: *Мари Есүсийн Үхэл ба Амиллыг Тайлбарласан нь*).

IX Хичээл: Есүсийг болон Түүний Өршөөлийг Мэдэхүй (Хэсэг: *Ривка Итгэгчид*).

X Хичээл: Есүстэй Хамт Амьдрахуй (Хэсэг: *Христитгэлийн Амьдрал*).

Бурхан таныг ерөөж, танаар дамжуулан хаанчлалаа тэлэх болтугай хэмээн бид залбирдаг.

I Хичээл Эмэгтэй Бүрийг Хардаг, Мэддэг

Мари Магдалена Ривкагийн Гэрт Очсон нь (Дуулал 139)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах

Цөлд төөрч, ганцаардаж гутарсан Хагар нэрт зарц бүсгүйтэй Бурхан уулздаг. Библид ийн бичжээ, “Хагар Түүнийг харсны дараа би энд амьд үлдлээ гэж үү?” гээд өөртэй нь ярьсан ЭЗЭНийг “Та бол хардаг Бурхан гэж нэрлэжээ.” (Эхлэл 16:13) Өнөөдөр бид бидний хүн нэг бүрийг үнэхээр хардаг, мэддэг Бурханы тухай сурч мэдэх аяллаа эхлүүлж байна.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Бүлгийн хэлэлцүүлэг. Анхаар: Бүх асуултыг гүйцээх шаардлагагүй.



Энэхүү QR кодыг ашиглан ухаалаг төхөөрөмж дээрээ сегментийг өөрийн эх хэлээр үзээрэй.

1. Түүхийн юу нь танд илүү их таалагдсан бэ? Юу таны анхаарлыг ихээр татав?
2. Ривка яагаад Бурхан өөрийг нь мэддэг бас хайрладаг гэдэгт эргэлзсэн бэ?
3. Бид өнөөдөр Бурханы тухай ихийг ярилаа. Бурхан бидний тухай яг юу боддог бас мэддэргийг бид яаж мэдэх вэ?
4. Дуулал 139:1-18. Зөнч Давид энэ бичвэрт Бурхан биднийг хэр сайн мэддэг талаар юу бичсэн бэ?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

5. Бурхан таны тухай бүх зүйлийг хардаг, ойлгодог гэдгийг мэдсэнээр танд ямар мэдрэмж төрж байна?
6. Бурхан таны тухай бүхнийг мэддэг ч үнэнчээр хайрладаг бас биднийг чиглүүлдэг, мөн үргэлж бидэнтэй хамт байдаг гэж Давид бичжээ. Бид яагаад заримдаа үүнд итгэж чаддаггүй вэ?

Дүгнэлт

Бүтээгч тань таныг бүрэн таньж, бүрэн хайрладаг гэдэг үнэнийг бясалган бодоорой. Хэрэв таны хэсэг бүр харагдаж, нуугдаж, нандигнагдсан бол ямар вэ? Есүс таны бүх бүтэлгүйтлийг уучлан өршөөж, амьдралын зорилго өгөхийг хүсдэг. Тэрээр өөрт нь ирсэн бүх хүмүүст мөнх амьдрал, мөнхийн оршихуйгаа амладаг. Та Бурханы дүр төрхөөр, Түүнтэй адилхан бүтээгдсэн. Та Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас эрхэмсэг бөгөөд үнэ цэнтэй (Эхлэл 1:26-27). Есүсийг Бодъё.



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

II Хичээл Есүс: Зөнчөөс Илүү Нэгэн

Марит Зарласан нь (Лук 1:26-37)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах

Есүсийг төрөхөөс хэдэн зуун жилийн өмнө эш үзүүлэгч Исаиа “Онгон бүсгүй хөл хүндтэй болж, хүү төрүүлнэ” гэдэг тэмдэг Израйлд өгөгдөх тухай зөгнөсөн (Исаиа 7:14). Энэ хүү бол Есүс бөгөөд бүх амьтай бүхний дундаас хамгийн сул дорой, нялх хүүхэд болж өөрийгөө даруу дорд болгосон. Тэрээр хүн байхыг бүрэн дүүрэн мэдэрч, өөрийгөө зөвхөн Бурхан төдийгүй бүрэн хүн гэдгээ харуулсан. Тэр бидэнтэй харилцах харилцаагаа сэргээхийн тулд шаналал, өвчин эмгэг, өлсгөх, цангах, уй гашуу, гашуудал зэргийг даван туулахад бэлэн байсан. Есүс онгон бүсгүй Мариас төрсөн.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн асуултууд:



Энэхүү QR кодыг ашиглан ухаалаг төхөөрөмж дээрээ сегментийг өөрийн эх хэлээр үзээрэй.

1. Түүхийн юу нь танд илүү их таалагдсан бэ? Юу таны анхаарлыг ихээр татав?
2. Тэнгэрэлчийн үгийг сонсоод Мари юу бодсон бол? Та байсан бол ийм мэдээ сонсоод юу мэдрэх байсан бэ?
3. Тэнгэрэлч “Бурханд боломжгүй юм нэг ч байхгүй” хэмээн хэлсэн. Яг одоо танд боломжгүй мэт санагдаж байгаа зүйл байна уу?
4. Тэнгэрэлч хүүг “Бурханы Хүү” гэж дуудагдах болно гэсэн нь ямар утгатай вэ?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

5. Есүс онгон бүсгүйгээс төрсөн нь яагаад чухал байсан бэ?

Дүгнэлт

Есүс бүрэлдсэн болон төрсөн гайхамшгийн талаар тунгаан бодоорой. Тэр бол Бурхан бөгөөд хүн. Тэр бол ертөнцийг Бүтээгч хийгээд хүн. Тэр бол бидэнтэй адилхан боловч Аврагч. Есүсийг Бодъё.



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

III Хичээл Хүлээснээс Чөлөөлөгдсөн нь

Мари Магдалена Чотгорүүдээс Чөлөөлөгдсөн нь (Лук 8:1-2)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах

Хүний наймаа, донтолт, бодит амьдралаас зугтах. Өнөөгийн дэлхий ертөнцөд олон төрлийн боолчлол бий. Хүн төрөлхтөн нүглийн боолчлолд байдаг боловч эрх чөлөөнд хүрэх зам бий хэмээн Библи сургадаг. Бидний үзсэн түүхэнд Мари чөтгөрт эзэмдүүлж боолчлогдсон байсан бөгөөд Есүсийн эрх мэдэл, хүч чадалтай учирсан.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн асуултууд:



Энэхүү QR кодыг ашиглан ухаалаг төхөөрөмж дээрээ сегментийг өөрийн эх хэлээр үзээрэй.

1. Түүхийн юу нь танд илүү их таалагдсан бэ? Юу таны анхаарлыг ихээр татав?
2. Мари боолчлолд байсан нь түүний зан чанар болон эргэн тойрны хүмүүстэй харилцахад яаж нөлөөлсөн бэ?
3. Мари Өөрийг илчлэх талаар Есүс ямар байр суурьтай байсан бэ?
4. Есүс Мариг чөлөөлсний дараа Мари яаж хувьсан өөрчлөгдсөн бэ?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

5. Чөтгөрүүд Есүсийн хэн болохыг мэдэж, Түүнийг “Бурханы Ариун Нэгэн” гэж дуудсан нь ямар утгатай вэ?
6. Есүс Мариг чөлөөлснийг хараад үзэгчид юу бодсон бол?
7. Хэрэв та эл түүхэн дэх Мари байсан бол, Есүсийн талаар та юу бодох байсан бэ?

Дүгнэлт

Эл түүхэн дэх Маригийн туршлагын талаар тунгаан бодоорой. Чөлөөлөгдсөнийхөө дараа түүний нүд яаж гэрэлтсэнийг, талархлаа хэрхэн илэрхийлснийг, түүний амьдрал яаж хувьсан өөрчлөгдсөнийг санаарай. Киноны уг хэсгийн эхэн дэх өнөөх эмэгтэй мөн гэдэгт та итгэх үү? Есүс таныг хүлээснээс болон боолчлолоос чөлөөлсний дараах тайтгарлыг төсөөлөн бодоорой. Та шинэ болохыг хэр их хүсдэг вэ? Нуруундаа үүрсэн хүнд ачаагаа Түүнд өгч, Түүнийг дагаарай. Есүсийг Бодъё.



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

IV Хичээл Есүсийн Энэрэл

Есүс Бэлэвсэн Эмэгтэйн Хүүг Амилуулсан нь (Лук 7:11-17)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах

Хэн нэгэн нас барснаас үүдсэн сэтгэлийн их гансралыг гашуудал гэдэг. Бидний үзсэн эл хэсэгт ганц хүү нь нас барснаас болж бэлэвсэн эмэгтэй гашуудаж байна. Есүс эмэгтэйд ойртон очиж зүрх сэтгэлийнх нь хэрэгцээг хангаж байгааг Мари харж зогсоно. Энэ удаад Есүс эмэгтэйн цор ганц хүүг эдгээж – түүний хамгийн эрхэм нандин бэлгийг буцааж өгөхөөр шийджээ. Есүс үргэлж ийн үйлдэхийг сонгохгүй байж болох ч ямар ч нөхцөл байдалд, туйлын ихээр шаналан гашуудаж байхдаа ч бид Түүний бодит оршихуйд түшиглэж болно.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн асуултууд:

1. Түүхийн юу нь танд илүү их таалагдсан бэ? Юу таны анхаарлыг ихээр татав?
2. Бэлэвсэн эмэгтэйтэй уулзахын тулд Есүс хийж байсан зүйлээ зогсоосон. Энэ нь Есүсийн зүрх сэтгэлийн талаар юуг илчилж байна вэ?
3. Үхсэн нэгнийг амилуулсан нь Есүсийн талаар юуг илэрхийлэв?
4. Та ямар ч найдваргүй мэт санагдсан нөхцөлд орж байв уу?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

5. Үхсэн хүүг Есүс амилуулахад хүмүүс ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ? Бэлэвсэн эмэгтэй юу хийсэн бэ?
6. Та одоо хэн нэгэн эсвэл ямар нэг зүйлийн хойноос гашуудан харуусаж байгаа юу? Хэрэв тийм бол гашуудлын хөндийгөөр туулан гарахдаа Бурханы тусламжийг авахыг хүсэж байна уу?

Дүгнэлт

Зөвхөн Бурхан л үхдэлд амийн амьсгал өгч чадна. Есүс бол Бурхан гэсэн үнэнийг тунгаан бодоорой. Есүс үхсэн нэгнийг амилуулсан, бас амилуулж чадна. Есүс үйлчлэлийнхээ туршид бэлэвсэн эмэгтэйн хүүгээс гадна өөр гурван хүнийг амилуулсан. Есүс хүчирхэг нэгэн төдийгүй өрөвч энэрэнгүй, зөөлөн сэтгэлтэй, тайтгаруулагч Нэгэн. Есүсийг Бодъё.



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

V Хичээл Зөрчил ба Гадуурхал

Худаг дээрх Эмэгтэй (Иохан 4:1-42)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах



Энэхүү QR кодыг ашиглан ухаалаг төхөөрөмж дээрээ сегментийг өөрийн эх хэлээр үзээрэй.

Та хэзээ нэгэн цагт шүүмжлүүлж, дорд үзэгдэж байв уу? Гадуурхагдсан Самари эмэгтэй өдөр тутмын ажиллаа хийж, худаг дээр ус авахаар ирсэн байсныг Мари харж зогсов. Эмэгтэй хүмүүстэй тааралдахгүйг хичээн, их үдийн халуун нарнаар худаг руу алхаж байв. Тэгээд худаг дээр иртэл эрэгтэй хүн сууж байхыг хараад гонсойжээ. Худаг дээрх өнөөх хүн ердийн нэг эр хүн биш, харин бүр Иудей хүн байх нь тэр. Самаричууд бол Иудей ба Иудей биш хүмүүсийн дундаас үүссэн бөгөөд итгэл үнэмшил, шашин шүтлэгийн хувьд холимог хүмүүс байлаа. Иудейчүүд, Самаричууд хэн хэнийгээ дорд үзэх боловч аль аль нь тэдний нүглийг өршөөх ирэх Аврагчийг хүлээдэг байв. Энэ мэт соёл уламжлалын зэвүүцлийг үл тоон өөртэй нь ярьсан Есүсийг хараад эмэгтэй хэр их гайхсан нь илэрхий. Эл түүхийн төгсгөлд гадуурхагдсан Самари эмэгтэй Есүс өөрийгөө Аврагч гэдгээ эл тод илэрхийлсэн анхны хүн болсон юм.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн асуултууд:

1. Түүхийн юу нь танд илүү их таалагдсан бэ? Юу таны анхаарлыг ихээр татав?
2. Есүс энэ эмэгтэйн өнгөрсөн бүх амьдралыг мэдсэн нь ямар утга учиртай вэ?
3. Есүс өөрийнх нь өнгөрсөн амьдрал болон өнгөрсөнд үйлдсэн нүглийг нь өөрт нь хэлэхэд эмэгтэйд ямар санагдсан бол?
4. Есүс Самари эмэгтэйтэй ярьж байхыг шавь нар харах үед тэдний ялгавар үзэл хэрхэн илэрсэн бэ? Энэ нь Есүсийн тухай юу илэрхийлэв?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

5. Энэ түүхэд Есүс шавь нартаа юу сургахыг хичээсэн бэ?
6. Есүс өөрийгөө амлагдсан Аврагч гэдгээ хэлэхэд эмэгтэй юу хийсэн вэ?

Дүгнэлт

Таны гаргасан буруу шийдвэр бүрийг, ичмээр мөч бүрийг болон өнгөрсөн бүх амьдралыг чинь Есүс мэддэг нь таны хувьд ямар ач холбогдолтой талаар бодоорой. Харин одоо, таны нүцгэн үнэнийг Есүс мэддэг ч таныг нэр төртэй, хүндтэй нэгэн гэж үздэг үнэнийг тунгаан бодоорой. Есүс таныг төдийгүй, таны үл тоодог хүмүүсийг ч ийн хүндэлдэг. Хүн бүрт Өөрийгөө таниулах Есүсийн хүслийн талаар тунгаан бодоорой. Есүсийг Бодъё.



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

VI Хичээл Эдгэрэл ба Сэргэлт

Цусны Өвчтэй Эмэгтэй (Лук 8:40-48)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах

Та хэзээ нэгэн цагт хэрэв боломжтой бол ямар ч хамаагүй аргаар байхгүй болгохыг хүсэж байсан бие махбодын эсвэл сэтгэлийн шархыг мэдэрч байсан уу? Хэнд ч мэдэгдэлгүй явж очоод зөвхөн Есүсийн хүрмийн хормойд хүрчихвэл эдгэнэ гэж найдсан эмэгтэй жил ирэх тусам улам доройтсоор байсан цус алдах өвчнөөсөө салж эдгэрсэн тухай уг хэсэгт гардаг. Тухайн үеийн шашны хуулийн дагуу тэрээр цус алдах өвчтэй байсан тул түүнийг шоовдорлож, цэвэр бус бузар гэж үздэг байв. Үй олон хүний дунд орсон тэрээр Есүст хүрэхээр зориг шулуудахыг Мари ойроос харж зогсоно. Юу болохыг үзэцгээе.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн асуултууд:

1. Түүхийн юу нь танд илүү их таалагдсан бэ? Юу таны анхаарлыг ихээр татав?
2. Есүс яагаад эмэгтэйд олны дунд өөрийгөө илчлэхэд хүргэсэн бэ?
3. Эмэгтэйн наманчлалд Есүсийн үзүүлсэн хариу үйлдэл яагаад чухал вэ?
4. Эл түүхэнд гарч байгаа эмэгтэй та байсан бол, эдгэрсний дараах мөчид танд ямар мэдрэмж төрж, Есүсийн талаар юу мэдрэх байсан бэ?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

5. Хэний ч хийж чадахгүй зүйлийг Есүс хийж чаддаг нь ямар утга учиртай вэ?
6. Есүстэй уулзахаас өмнө энэ эмэгтэйн амьдрал ямар байсан бол?

Дүгнэлт

Олон түмний дунд эмэгтэй гараа сунган Есүсийн хүрэмд хүрсэн. Хүрэмд хүрсэн даруй өөрийнх нь бие эрүүлжин сэргэхийг эмэгтэй мэдэрчээ. Тэр эдгэрсэн! Түүний сэтгэлд дүүрсэн тайтгарал ба талархал ямар их байсан бол. Есүс, “Охин минь, итгэл чинь чамайг эдгээлээ. Амар тайван яв” хэмээн айлдсан. Есүсийн үгийг тунгаан бодоорой. Есүс эл үгийг эмэгтэйн наманчлалын дараа л айлдсан. Түүнийг цэвэр бус бузар хэмээн үзсэн үй олон хүний өмнө Есүс түүнийг охин минь хэмээн дуудаж, итгэлийг нь сайшаан хүндэтгэсэн. Есүс бидний мэдэрдэг өвдөлт, шархад санаа тавьдаг. Есүс бидэнтэй эмтэрсэн сэтгэл, ичгүүрийн дунд уулзахыг хүсдэг. Есүсийг Бодъя.



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

VII Хичээл Ичгүүр ба Хүндлэл

Завхайрсан Эмэгтэй Өршөөгдсөн нь (Иохан 8:1-11)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах

Есүсийн үеийн шашны удирдагчид “Мосегийн Хууль” гэх нэртэй цогц хуулийг баримталдаг байжээ. Хүмүүс Бурхантай харилцаатай байхын тулд уг хуулийг төгс даган биелүүлэх ёстой байв. Харамсалтай нь бид бүгд нүгэл гэдэг нийтлэг бэрхшээлтэй учраас хэн ч хуулийн заалт бүрийг төгс биелүүлж чаддаггүй. Еврей хэлний нүгэл гэх үг “унах” буюу “зорилгоо алдах” гэсэн утгатай. Хуулийн дагуу бид бүгд буруутай учраас үхэх ял авах ёстой. Аврагч үгүй бол бид бүгд сүйрэх тавилантай. Гэвч Есүс газар дэлхий дээр ирж, бидний нүглийн төлөөсийг төлөхийн тулд өөрийгөө золиосолсон. Эл түүхэнд нүгэлт эмэгтэйг Есүс дээр авч ирдэг. Хамтдаа юу болохыг үзэцгээе.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн асуултууд:

1. Түүхийн юу нь танд илүү их таалагдсан бэ? Юу таны анхаарлыг ихээр татав?
2. Хуулийн дагуу, завхайрсан эрэгтэй, эмэгтэй хоёулаа шийтгэгдэх ёстой байв. Гэвч тэд зөвхөн эмэгтэйд л барьж Есүсийн өмнө авч иржээ. Яагаад зөвхөн эмэгтэйд л шүүхийн тулд авч ирсэн бэ?
3. Шашны удирдагч болон эмэгтэйд аль алинд нь өгсөн Есүсийн хариулт яагаад чухал вэ?
4. “Би ч чамайг шийтгэхгүй” хэмээн Есүсийг айлдахад эмэгтэй юу мэдэрсэн бол?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

5. Есүс яагаад ийн хариулсан бэ? Есүс тэдэнд юу ойлгуулахыг хүссэн бэ?
6. Хэрэв та шашны удирдагчдын нэг байсан бол, та Есүст ямар хариулт өгөх байсан бэ?

Дүгнэлт

Шашны удирдагчид болон эмэгтэйд өгсөн Есүсийн хариултыг эргэцүүлэн бодоорой. Тэд эмэгтэйтэй завхайрсан эрэгтэйд авч ирээгүй нь зөвхөн бүсгүйг шившиглэж, Өөрийг нь урхинд оруулах санаатай байсныг Есүс мэдэж байсан. Есүс бүсгүйн үйлдлийг зөвтгөхийг ч эсвэл шашны удирдагчидтай адил зүйл хийхийг сонгоогүй. Есүс бүгдийг нь ухаалгаар гэмшилд хөтөлсөн. Есүс аль аль талыг хэрхэн гэмшилд хөтөлснийг бодоорой. Есүс гэм нүглийг уучлах чадвартай – зөвхөн Бурханы л хийх зүйл – Есүс Бурхан учраас ийн үйлдсэн. Бид Есүсийн дагалдагчид болохоор шийдэхэд Тэр биднийг уучилж, Өөрийн дотор шинэ амийг өгдөг. Есүсийг Бодъё.



Энэхүү QR кодыг ашиглан ухаалаг төхөөрөмж дээрээ сегментийг өөрийн эх хэлээр үзээрэй.



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

VIII Хичээл Есүсийн Үхэл ба Амилал

Мари Есүсийн Үхэл ба Амиллыг Тайлбарласан нь (Матай 27-28)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах

Есүсийг үхсэн шөнө эмэгтэйчүүд Есүсийн биед түрхэх үнэрт тосыг бэлтгэхээр гэрлүүгээ яаран явав. Дараа өдөр нь тэд Амралтын өдрийг сахиж, дараа өдөр Эзэнийхээ биеийг эргэхээр ирнэ гэж найдан амрав. Есүс зодуулсныг санахад нүднээс нь нулимс асгарч, Түүний үхлийг бодоход сэтгэл нь өвдөж байлаа. Тэдний эрхэм анд, хамгаалагч, Хаан нь үхсэн.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн асуултууд:

1. Түүхийн юу нь танд илүү их таалагдсан бэ? Юу таны анхаарлыг ихээр татав?
2. Есүсийн үхлийн талаар Хуучин Гэрээний зөнчид зөгнөсөн нь яагаад чухал вэ?
3. Бидний нүгэл ба үхлийн хараалын талаар Мари дурдсан. Есүсийн үхэл яаж энэ хоёрыг ялсан бэ?
4. Мари Ривкад “Чи бол нандин охин” хэмээн хэлдэг. Бурхан биднийг нандигнан хайрладаг болохыг Есүсийн үхэл ба амилал яаж илэрхийлсэн бэ?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

5. Есүс үхсэнийхээ дараа Мари болон шавь нартаа хэд хэдэн үзэгдсэн нь ямар ач холбогдолтой байсан бэ?
6. Дуулал 22-р бүлгийг хамтдаа уншаарай. Аль эшлэл Есүс Аврагч болохыг баталж байна вэ?
7. Есүсийн үхэл болон дахин амиллын дунд гурван өдөр өнгөрсөн. Есүсийг үхсэний дараа шавь нар юу мэдэрсэн бол?

Дүгнэлт

Зөнч Исаиагийн “Гэвч гэмт үйлдлийн маань улмаас Тэр хатгагдан Хилэнцийн маань улмаас Тэр бяцарч авай. Амар тайвны маань төлөө Түүн дээр гэсгээл байж, шархаар нь бид эдгэрчээ.” (Исаиа 53:5) гэх үгсийг эргэцүүлэн бодоорой. Есүс хүмүүсийг нандигнасан. Есүс хүмүүсийг ихэд эрхэмлэн хайрласан учраас бидний төлөө хараалыг үүрч, Бурханаас тусгаарлагдаж, үхсэн. Улмаар Есүс үхлээс дахин амилахдаа Бурхан гэдгээ баталсан юм. Үхэл ба амиллаараа харуулсан Есүсийн өршөөл ба хүчний тухай бодоорой. Есүсийг Бодъё.



Энэхүү QR кодыг ашиглан ухаалаг төхөөрөмж дээрээ сегментийг өөрийн эх хэлээр үзээрэй.



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

IX Хичээл Есүсийг болон Түүний Өршөөлийг Мэдэхүй

Ривка Итгэгчид (Лук 24:36-50)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах

Мари Бурханы түүхийг хүүрнэсэн цувралын төгсгөлд бид иржээ. Тэр бидний хүн нэг бүрийг хардаг, мэддэг. Есүс бол Аврагч, мах биеэр ирсэн Бурхан, хүлээнэс чөлөөлж, эрх чөлөөг өгдөг. Есүс бол үхсэн нэгнийг амилуулах хүчтэй, сэтгэлийн гүн дэх уй гашуут тайлдаг өрөвч Нэгэн. Түүнд бидний нүглийг өршөөх, чөлөөлөх тэр бүү хэл хамгийн шившигт, аймшигт үйлдлийг ч өршөөн цагаатгах эрх мэдэл бий. Мөн үхэлд ч Түүний үг эцсийнх. Ривка Есүст хэрхэн хариулсныг үзэцгээе.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн асуултууд:

1. Мари Есүсийн амьдралыг өгүүлсний юу нь танд илүү таалагдсан бэ? Юу таны анхаарлыг татав?
2. Есүсийн ямар чанар танд чухал санагдав?
3. Бидний нүгэл Бурханы өмнө хэрхэн цагаатгагдах вэ?
4. Ривка өөрийгөө өршөөгдөж уучлагдана гэдэгт итгэлгүй байсан. Эцсийн эцэст өөрийн мэдрэмж, үйлдэлд бус харин Бурханы үг, өршөөлд итгэх нь яагаад чухал вэ?
5. Та нарын хэн нэг чинь Ривкаг залбирахад хамт залбирсан уу? Залбирах хүсэлтэй хүн байна уу?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

6. Есүсийн дагалдагч авралынхаа талаар бат итгэлтэй байх нь яагаад чухал вэ?
7. Ривкагийн эргэлзээ танд ч бас байна уу? Хэрэв тийм бол, та эргэлзээ эсвэл санаа зовнилоо хуваалцаарай.
8. Та одоо амьдралаа Есүст өгөхийг хүсэж байна уу?

Дүгнэлт

Киноны эл хэсгээр Ривка Есүсийг дагах шийдвэр гаргаж байгааг бид үзлээ. Есүсийг дагахын утга санаа болон энэ нь таны амьдралд ямар ач холбогдолтой болохыг бодоорой. Та нүглээс чөлөөлөгдөхийг хүсдэг үү? Өршөөгдөж, чөлөөлөгдөхийг хүсдэг үү? Харагдаж, танигдахыг хүсдэг үү? Түшиж тулах хэн нэгэнтэй болохыг хүсдэг үү? Нүглийнхээ төлөө чин сэтгэлээсээ гэмшин гашуудахыг л Есүс биднээс хүсдэг. Та нэгэнт Есүс дээр ирсэн л бол Есүс өдгөө хийгээд өнөд таныг харж, итгэлийг чинь сайшаан хүндэтгэнэ гэдэгт итгэлтэй байж болно. Та Есүсийн талаар бодож эргэцүүлсэн. Тиймээс шийдвэр гаргах цаг болжээ. Та Түүнийг дагах уу?

* Удирдагчийн анхааралд: Хүмүүст Есүсийг дагах шийдвэр гаргах боломж олгох нь тун чухал. Бүлгээс “Ривкаг залбирахад хамт залбирсан хүн байна уу? Залбирах хүсэлтэй хүн байна уу?” гэж заавал асуугаарай. Хэрэв зохистой бол бүлгээс гадуур хүн нэг бүртэй хувьчлан уулзаарай.



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

Х Хичээл Есүстэй Хамт Амьдрахуй

Христитгэлийн Амьдрал (Матай 28:18-20)



Эргэж Харах

Халамж

- Ямар байгаагаа хуваалцах.
- Өгөөмөр зочлох.

Магтаал

- Магтаалын дуу болон залбирлаар хамтаа магтан хүндэтгэх.

Итгэмжит чанарыг тэмдэглэ

- Нэг нэгнийхээ ялалтад уриалах.

Алсын Хараанд Уриалах

- Есүсийн дагагчид зүтгэлтэй байхад нэг нэгнээ урамшуулах.



Дээшээ Харах

Мари Есүсийг дагаснаараа хувьсан өөрчлөгдсөн шиг та ч бас хувьсан өөрчлөгдөх боломжтой. Есүс биднийг илүү агуу зүйлд уриалан дууддаг. Тэр бол Есүсийн мөн чанараар амьдарч, нэр төр, итгэл найдвар, сайн сайхан амьдрах зорилго юм. Биднийг өөрчилсөн амийн үгийг бусадтай хуваалцахыг Есүс бидэнд даалгасан. Тэр бидэнтэй хамт байдгийг мэдэж, Түүний Үг болон тушаалд итгэхийг даалгасан. Есүс бидний амьдралын хэсэг бүрийг мэддэг ба ойлгодог тул биднийг Өөрийнх нь дотор тайван амар хэмээн уриалан урамшуулдаг.

Алхам 1: Үзүүлэх. Хэсгийг хоёр удаа үзнэ.

Алхам 2: Ярих. Киноны хэсгийг өөрийн ойлголтоор ярихыг бүлгийн нэг гишүүнээс асууна.

Алхам 3: Гүйцээх. Түүхээс дутуу ярьсан зүйл байвал гүйцээж ярихыг бусдад уриалах.

Алхам 4: Хэлэлцүүлэг. Хэлэлцүүлгийн асуултууд:

1. Христитгэлт амьдралын юу танд таалагдсан бэ? Юу таны анхаарлыг татав?
2. Есүсийг дагана гэдэг нь ямар утгатай вэ?
3. Есүсийн сүүлийн үг танд яаж нөлөөлсөн бэ?
4. Та амьдралынхаа аль талбарыг Есүсээр хувьсган өөрчлүүлэхийг хүсэж байна вэ?

Гүнзгийрүүлэх (хэрэв цаг байвал)...

5. Есүсээр амьдралаа хувьсган өөрчлүүлэхээс та яагаад айдаг вэ?
6. Есүсийн үг таныг яаж ятгасан бэ?

Дүгнэлт

Есүсийн шавь нартаа айлдсан сүүлийн үгнээс гурван чухал зүйлийг эргэцүүлэн бодоорой. Есүс өөрт нь тэнгэр газар дээрх бүх эрх мэдэл өгөгдсөн хэмээн тунхагласан. Есүс бидэнд явж дагалдагчдыг бэлтгэж, Өөрийнх нь тушаасан бүхнийг заан сургахыг тушаасан. Улмаар үеийн төгсгөл хүртэл бидэнтэй хамт байхаа батлан өгүүлсэн. Есүсийн сүүлийн тунхаг, тушаал, батламжийг амьдралдаа тусган харуулж амьдрах нь ямар утга учиртай болохыг эргэцүүлэн бодоорой. Есүсийг Бодъё.

Та Есүсийг дагаж амьдрахад бэлэн байгаа эсэхээс үл хамааран Түүний тухай болон Түүнийг хэрхэн дагах талаар сурахыг хүсэж байна уу? Сүнсээр хамтдаа өсөн төлөвшиж, сурахад туслах өөр нөөц боломжууд бий. Хэдийгээр Есүсийг Бодъё хөтөлбөр үүгээр дуусаж байгаа ч дараагийн хэд хэдэн алхам бий. Та бүхний хүн нэг бүр чинь дараа нь ямар алхам хийж болохыг хамтдаа ярилцаарай. Есүс Кино Төсөл Риква болон Есүсийг Мэдэхүй хөтөлбөрүүдийг санал болгодог. Удирдагчийн Хөтчийн Алхам 4-т нэмэлт мэдээлэл бий. **Мөн та өөрийн сурсан зүйлээ бусдад хуваалцаж, Есүсийг Бодъё хөтөлбөрийг бие даан эхлүүлж болно. Хэрэв энэ нь таны дараагийн алхам бол бүлгийн удирдагчаасаа зөвлөгөө, дэмжлэг аваарай.**



Урагшаа Харах

Хэрэгжүүлэх

- Бурхан итгэмжит болохоо яаж харуулсан бэ?
- Бурханы тухай сурсан зүйлээ та яаж хэрэгжүүлэх вэ?

Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярьж өгч дадлагажаарай.

Хуваалцах

- Та энэ түүхийг хэнд ярьж өгөх вэ?

Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархаарай.
- Нэг нэгнийхээ төлөө залбираарай.
- Орон нутгийнхаа хүмүүсийн төлөө залбираарай.

Есүсийг Бодъё

Нутгийн жижиг бүлгүүдэд зориулсан 10
долоо хоногийн стратеги